



Төв аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс



ТӨВ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2018/7





Хүн ам, улсын бүртгэл

Хүн ам

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 7 сард төрсөн хүүхэд 1187; нас барсан хүн 320; бусад аймаг, хот руу шилжин явсан 731; бусад аймаг хотоос шилжин ирсэн 1160 хүн бүртгэгдлээ. Төрсөн хүүхдийн 86.4, нас барсан хүний 96.3 хувь нь хүн ам, өрхийн мэдээллийн сан(ХАӨМС)-д оруулжээ.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 7 сард нийт 7792 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 314; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 3; төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 6; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 2711; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 29; бэлэглэлийн гэрээ 197; худалдах, худалдан авах гэрээ 607; өв залгамжлал 89; барьцааны гэрээ 1759; бусад бүртгэл 2077-г тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2018 оны эхний 7 сард нийт 96 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 52; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 15; нөхөрлөл /ЗБН/ 18, /ББН/ 2; Хоршоо 3; сан 2; төсөвт 1; банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ 3 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2018 оны эхний 7 сард 140 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 43; гишүүн нэмэгдсэн хасагдсан 3; дүрэм шинэчилсэн 7; дахин гэрчилгээ 16; удирдлага өөрчлөгдсөн 26; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 18; дүрмийн сан нэмэгдсэн хасагдсан 10; хаяг өөрчлөгдсөн 1; нэр хэлбэр өөрчлөгдсөн 3; татан буугдсан 9; өв залгамжлал 3; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүллээ.




Нийгмийн даатгал, нийгмийн халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2018 оны эхний 7 сард НДШ-ийн орлого 10.3 тэрбум.₮ болж төлөвлөгөө 103.7 хувь биелэлээ. Төлөвлөгөөг Алтанбулаг 1.8%, Зуунмод 3.8%, Заамар 6.4%-аар тус тус тасалдуулж, Баянжаргалан сум 1.6 дахин бусад 23 сум 0.5-25.4 хувиар давуулан биелүүллээ. Сайн дурын НДШ-ийн орлого 1.6 тэрбум ₮ болж төлөвлөгөөг 177.6 хувь биелэлээ. Төлөвлөгөөг Зуунмод 4.6 дахин, бусад 15 сум 0.8-91.9 хувиар давуулан биелүүлж, 11 сум 0.6-31.8 хувиар тасалдуулав.

Тэтгэвэр, тэтгэмжид 29.0 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.8 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.6 хувийг тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 308638.3 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 33.1 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 25.3%; тэтгэмжийн даатгалын сангийн 72.1%; эрүүл мэндийн даатгалын сангийн 121.1%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 70.0%; ажилгүйдлийн даатгалын сангийн 53.5%-ийг тус тус бүрдүүлжээ.



2018 оны эхний 7 сард нийгмийн даатгалын сангийн авлага 877.5 сая.₮, өглөг 539.7 сая.₮ боллоо.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 7 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 52162 хүнд олгож, 10.0 тэрбум ₮-ийг зарцуулж 2017 оны мөн үеэс хүний тоо 11.6 хувь 6855 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 4.8 хувь 460.0 сая ₮-өөр тус бүр буурлаа.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 137200 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 34.3 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 18.3 хувийг халамжийн тэтгэвэр; 8.2 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 5.0 хувийг насны хишгийн зардал; 2.3 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 2.6 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; тусламж: 0.9 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 0.6 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тус бүр зарцуулжээ.





Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2018 оны эхний 7 сард 668 хүүхэд мэндэлсэн нь 2017 оны мөн үеэс 48 хүүхдээр буурлаа.

Он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 6 хүүхдээр өслөө.




Эмнэлгийн мэдээгээр 2018 оны эхний 7 сард 282 хүн нас барсан нь 2017 оны мөн үеэс 15.6 хувиар өслөө. Нас барсан хүний 17.0 хувь буюу 48 нь эмнэлэгт нас баржээ. Нас баралтыг шалтгаанаар аваад үзвэл хорт хавдарын нас баралт хамгийн өндөр 21.9 хувь, гадны шалтгаан 15.2 хувийг эзлэв.

2018 оны эхний 7 сард халдварт өвчнөөр 406 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 21.5 хувь буюу 111 хүнээр буурлаа. Халдварт өвчлөлийг өмнөх онтой харьцуулбал бруцеллөз 2 дахин, вируст гепотит 1 дахин, цусан суулга 71.4 хувь өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 44 байгаа бол: Баян 143, Зүүнмод 143, Сүмбэр 81 ногдлоо.

10000 хүнд ноогдох халдварт өвчний тоог газрын зургаар харуулвал.

	Интервал-хүнээр	Сумын тоо
	2-11	8
	12-19	7
	20-31	7
	32-143	5
	0	0

Сум хилийн зааг





АЖИЛГҮЙЧҮҮД

2018 оны 7 дугаар сард ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 466 болж, 2017 оны мөн үеэс 176 хүнээр, өмнөх сарынхаас 163 хүнээр тус тус буурчээ.

Ажилгүйчүүдийн 53.6 хувь буюу 250 нь эмэгтэйчүүд юм. 2018 оны эхнээс 1160 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 575 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 44.3 хувь буюу 255 нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн бүртгэлээс оны эхнээс 1517 иргэн хасагдлаа.

Аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 25.6 хувь нь Зуунмод суманд; 17.8 хувь нь Батсүмбэр суманд; 8.4 хувь нь Жаргалант суманд; 6.9 хувь нь Мөнгөнморьт суманд; 6.0 хувь нь Баяндэлгэр суманд бүртгэгджээ.




Тайлант сард бүртгүүлсэн 119 ажилгүй иргэний 45.4 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 25.2 хувь нь шилжин суурьшсан; 5.0 хувь нь цэргээс халагдсан; 1.7 хувь нь байгууллага татан буугдсан; 0.8 хувь нь орон тооны цомхтголд орсон; 0.8 хувь нь тэтгэвэрт гарсан; 21.0 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын түвшингөөр хуваавал 16.3% нь дээд; 3.0% нь тусгай дунд; 5.8% нь мэргэжлийн анхан шатны; 64.4% нь бүрэн дунд; 7.7% нь бүрэн бус дунд; 0.4% нь бага боловсролтой; 2.4% нь боловсролгүй иргэд юм.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд дунджаар 81 ажилгүйчүүд ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 31 хүнээр бага байна. Аймгийн дундажтай сумдын дунджийг харьцуулбал Жаргалант, Зуунмод, Сэргэлэн, Баянцагаан, Баян, Батсүмбэр, Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдад аймгийн дунджаас олон ажилгүйчүүд (98-293 хүн) ногдов.


Тайлант сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд зуучлуулсан 42 иргэний 57.1 хувь нь бүрэн дунд; 19.0 хувь нь дээд; 16.7 хувь нь бүрэн бус дунд; 7.1 хувь нь тусгай дунд боловсролтой иргэд байв.

2018 оны эхнээс ажлын шинэ байранд 626 иргэн ажилд оржээ. Эдийн засгийн салбарын ангиллаар ангилбал 31.3 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын; 27.0 хувь нь Боловсруулах үйлдвэрлэлийн; 12.9 хувь нь Зочид буудар, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний; 9.6 хувь нь Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний; 6.2 хувь нь Уул уурхай олборлолтын салбарт; 2.6 хувь нь Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; 2.1 хувь нь барилгын; 1.8 хувь нь Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны; 1.4 хувь нь Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны; 1.3 хувь нь Боловсролын; 1.4 хувь нь Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; 0.8 хувь нь Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны; 0.3 хувь нь Цахилгаан, хий, уур, агааржуулалтын; 0.3 хувь нь Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны; 0.2 хувь нь Урлаг, үзвэр, тоглоом наадмын үйл ажиллагааны; 1.0 хувь нь Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбаруудад тус тус ажилд орлоо.



10000 ХҮН АМД НОГДОХ АЖИЛГҮЙНҮҮДИЙГ СУМДААР ҮЗҮҮЛБЭЛ:

Интервал-хүнээр	Сумын тоо
0-15	7
16-37	7
38-116	7
117-293	6



Байгаль орчин

Цаг агаарын тойм

Төв аймгийн 2018 оны 7 сарын цаг агаарын байдлыг

-агаарын дундаж температур 15-21 градус дулаан буюу Өндөрширээт орчмоор дулаан, Мөнгөнморьт орчмоор сэрүүвтэр

-өдөр ажиглагдсан агаарын хамгийн их температур нь 28-35 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсгээр буюу Мөнгөнморьт, Эрдэнэ, Эрдэнэсантад 28-29 градус дулаан, ихэнх нутгаар 32 градус буюу давж халсан ба Өндөрширээт, Баян-Өнжүүлд 35 градус, Алтанбулагт 34 градус хүрч халсан. -шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 1 градус хүйтнээс 9 градус дулаан буюу нутгийн баруун хэсгээр дулаавтар, Лүн, Заамар, Эрдэнэсант, Өндөрширээт орчмоор 7-9 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсгээр сэрүүвтэр, үүнээс Мөнгөнморьтод 1 градус хүйтэн, Эрдэнэд 0 градус орчим, Батсүмбэрт 2 градус дулаан ажиглагдсан.

-Сарын нийлбэр тунадас 57.9-136.4 мм, Нутгийн зүүн хэсгээр ахиу хамгийн их нь Мөнгөнморьт, Эрдэнэд 136.4 мм, Баянжаргаланд 133.8 мм, Мааньтад 131.7 мм бороо, түр зуурын дуу цахилгаантай бороо оржээ. Хамгийн бага нь Лүнд 57.9 мм бороо орсон байв.

-Салхи ихэнх хугацаанд баруун хойноос 5-10 м/с, борооны өмнө ихэнх нутгаар 12-14 м/с, зарим газраар 16-18 м/с, түр зуур 20 м/с хүрч нөөлөг салхи ажиглагдлаа.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт


Цаг агаарын үзүүлэлтүүдийг 2017 оны 7-р сартай харьцуулахад

-агаарын дундаж температур нь нийт нутгаар 2-5 орчим градусаар сэрүүн

-өдрийн хамгийн их температур нийт нутгаар 3-8 градусаар сэрүүн ажиглагдсан
-шөнийн хамгийн бага температур нь нийт нутгаар 1-7 градусаар сэрүүсч ажиглагдсан.
сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд нийт нутгаар ахиу бороо орсон байна.

2017 оны 7-р сард ихэнх өдрүүддээ 32 градусыг давж, зарим өдрүүдэд нь ихэнх нутгаар 33-40 градус хүрч халалттай хоногууд үргэлжилж, таримал болон бэлчээрийн ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлж, гандах нөхцөл бүрдэж, халалт ихтэй, хур бороо багатай, ургамлын өндөр 6-19 см байв.

Харин энэ оны 07-р сард халалт багатай, хур бороо нийт нутгаар уур амьсгалын дунджаас ахиу орж, ургамлын өндөр 7-24 см болсон байгаа нь 2017 оны 07-р сарынхаас ихэнх нутгаар 1-7 см-ээр, зарим газраар 8-20 см -ээр өндөр байгаа бөгөөд таримал болон бэлчээрийн ургамлын ургалтанд сайнаар нөлөөлж, зуншлага сайжрах нөхцөл бүрдэж, 8-р сарын 01-ний байдлаар нийт нутгийн 90 гаруй хувь нь зуншлага хэвийн буюу сайн, Баянцагаан сумын нутгаар дунд зэрэг байна.



2018 ОНЫ НАЙМДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын температурын дундаж нь Төв аймгийн нутгаар 16-21 градус дулаан буюу Баянцагаан, Баян, Баянжаргалангийн зүүн өмнөд хэсгээр дунджаас 0.5-1.5 градусаар дулаан, бусад нутгаар дундгийн орчим байх төлөвтэй.

Бага зэрэг сэрүүсэх үе: Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр нутгийн зүүн хойд хэсгээр шөнөдөө 1-6 градус, өдөртөө 15-20 градус, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 19-24 градус дулаан.

Сэрүүсэх үе: Гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн зүүн хойд хэсгээр шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүйтэн, хөрсөн дээр 0-5 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 10-15 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 15-20 градус дулаан.

Бусад хугацаанд: Нутгийн зүүн хойд хэсгээр шөнөдөө 6-11 градус, өдөртөө 19-24 градус, бусад нутгаар шөнөдөө 10-15 градус, өдөртөө 23-28 градус дулаан.

Хур тунадас: Энэ сард Төв аймгийн баруун хойд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, зүүн өмнөд хэсгээр дунджаас бага, бусад нутгаар дундгийн орчим бороо орох төлөвтэй. Дунджаар ихэнх нутгаар 42-70 мм, харин Жаргалант, Борнуур, Эрдэнэ, Мөнгөнморьтын хойд хэсэг, Сүмбэр, Батсүмбэр орчмоор 70-98 орчим мм тунадас ордог.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр ихэнх нутгаар, нэг, хоёрдугаар

арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа нэг ба гуравдугаар арав хоногийн дунд, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар түр зуур 14-16 м/с хүрч ширүүснэ.


Төрийн хяналт

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2018 оны эхний 7 сарын мэдээгээр нийт 188 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 249; үүнээс тохирлын гэрчилгээ 199, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 8545; цулын хэмжүүр 379, үүнээс жин 330 автомашины жин 1, туухай 48; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 292, үүнээс түгээгүүрийн хошуу 236, мерник 14, сүмбэн метр 22, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 2, уртын хэмжих хэрэгсэл 12, усны тоолуур 6, нэг фазын тоолуур 7769, гурван фазын тоолуур 105, тус бүр баталгаажууллаа.

Санхүүгийн хяналт, шалгалт

Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны эхний 7 сард 75 нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 349.8 сая ₮-ийн зөрчил, төлбөр илэрч төлүүлвэл зохих төлбөрийн барагдуулалт 141.2 сая ₮ болж 68.4 хувийн биелэлтэй гарлаа.





Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2018 оны эхний 7 сард аймгийн хэмжээнд 495 гэмт хэрэг бүртгэгдэж 189 хүн холбогдож, иргэдийн өмчид 6.7 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.


Гарсан гэмт хэргийн 29.5 хувь нь хулгай, 25.4 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг хэрэг, 11.0 хувь нь замын осол, 7.6 хувь нь хүний амь, 0.2 хувь нь танхай дээрэм, 26.2 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Баянхангай, Сэргэлэн, Аргалант, Баян, Заамар, Эрдэнэ, Баянчандмань, Баяндэлгэр, Лүн сумдад 10000 хүнд 227-92 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (76)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2017 оны мөн үеэс 14 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 22 эмэгтэй, 472 эрэгтэй нийт 494 хүн эрүүлжүүлэгдлээ.



Гарсан гэмт хэргийн 13.2 хувь нь бүлгээр 20.1 хувь нь согтуугаар үйлдэгджээ.
Гэмт хэргийн улмаас 132 хүн гэмтэж, 76 хүн нас барлаа.



Интервал-хүнзэр	Сумын тоо
6-39	7
40-59	7
60-101	7
102-227	6

Интервал-хүнээр	Сумын тоо
6-39	7
40-59	7
60-101	7
102-227	6

Сумын хийгн цэс

Монголморьт 74

Батсүмбэр 54

Борнуур 57

Жаргалант 33

Сүмбэр 47

Цэцэг 6

Угтаал 27

Баяндалмань 101

Баяндал 65

Архангай 208

Баяндалмань 227

Лүн 92

Эрдэнэсант 52

Өндөрширээт 43

Алтанбулаг 56

Зуунмод 75

Архуст 33

Баяндалмань 92

Баян-Өмнөд 39

Бүрэн 32

Дэлгэрхаан 68

Баяндалмань 138


Баяндалмань 222

Баяндалмань 138

Баяндалмань 26

Баяндалмань 59

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2018 оны эхний 7 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 728 гүйцэтгэх хуудсанд нийт 5.7 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс биелүүлбэл зохих 676 гүйцэтгэх хуудасны 4.8 тэрбум ₮-өөс 203 хуудасны 1.1 тэрбум ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 30.0 хувь, үнийн дүнгээр 23.4 хувь болж 2017 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 13.5 нэгжээр буурч, үнийн дүнгийн биелэлт 5.0 нэгжээр өслөө.





ТӨСӨВ, МӨНГӨ

Төсвийн орлого 2018 оын эхний 7 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 8.8 тэрбум ₮, зарлага 48.9 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 132.7 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; байгалийн ургамал; түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр; түрээсийн орлого; төрийн өмч худалдсаны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2017 оны мөн үеэс 9.9 хувь буюу 793.5 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 85.0 хувийг татварын, 14.5 хувийг татварын бус орлого, 0.5 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2017 оны мөн үеэс татварын бус орлого 2.0 нэгжээр өсч, татварын орлого 1.7 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.3 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 16.6 тэрбум ₮ болж аймгийнх 6.3 тэрбум ₮ буюу 38.3 хувь; сумынх 2.5 тэрбум ₮ буюу 14.9 хувь; улсынх 7.8 тэрбум ₮ буюу 46.8 хувийг тус бүр бүрдүүлжээ.



2017 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 12.6 хувь буюу 42.1 сая ₮-өөр буурч 291.1 сая ₮ болж, авлага 73.7 хувь буюу 102.9 сая ₮-өөр өсч 242.5 сая ₮ боллоо.




Орон нутгийн төсвийн орлого 8.7 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 127.6 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 2.4 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 170.7 хувь биелж Дэлгэрхаан, Баянхангай, Сүмбэр, Баянцогт, Өндөрширээт сумд 34.0-1.8 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 6.3 тэрбум ₮ болж 122.2 хувь биелж Угтаал, Архуст, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Бүрэн, Баянхангай, Баянцагаан сумд төлөвлөгөө 15.7-0.2 хувиар тасалдууллаа.


Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2018 оны эхний 7 сард кассын орлого 193.8 тэрбум ₮, кассын зарлага 147.9 тэрбум ₮ болж, гүйлгээнд 168.9 тэрбум ₮ байна.


ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 34628, зээлийн багцын дүн 179.5 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 11000, олгосон зээлийн дүн 82.5 тэрбум ₮ боллоо.




Иргэдийн хувийн хадгаламжинд 7 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 53.7 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 19.0 тэрбум ₮ байна.



Иргэдийн харилцах дансны үлдэгдэл 7 сарын 31-ны байдлаар 62065 иргэний 14.0 тэрбум ₮ боллоо.



ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-1.5 хувь, хугацаатай доод хүү 0.1-0.7 хувь, хугацаагүй дээд хүү 0.6 хувь, хугацаагүй доод хүү 0.1-0.6 хувьтай байна.






ҮНЭ, ТАРИФ



а. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2018 оны 7 дугаар сард 2015 оны эцсээс 14.8 хувь; өмнөх оны мөн үеэс 7.8 хувь; оны эхнээс 4.8 хувь; өмнөх сараас 0.3 хувиар тус тус өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 2018 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 12.5 хувь; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.0 хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 10.3 хувь; хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувь; орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.6 хувь; тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 8.4 хувь өссөн нь голлон нөлөөлсөн. Мөн гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь; эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь; бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь; амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувь; холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ, боловсролын үйлчилгээний үнэ тус тус 0.1 хувиар өсчээ.


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.3 хувиар өсөхөд тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь; эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь; хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн энэ сард өмнөх сараас гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь; орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь; бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувиар тус тус буурав.

2018 оны 7 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 238 нэрийн бараа, үйлчилгээний 11.8 хувийнх нь үнэ өсөж; 10.5 хувийнх нь үнэ бууран; 73.5 хувийнх нь үнэ тогтвортой байв.






2018-07/2017-07



2018-07/2017-12





б. Хөдөөд 2018 оны 7 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф суурь он буюу 2015 оны 12-р сартай харьцуулахад 11.2%, 2017 оны 7-р сартай харьцуулахад 8.4%-аар өсч, өмнөх сартай харьцуулахад 0.2%-аар буурав.




АЖ ҮЙЛДВЭР

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 7 сард (2010 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 35.1 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2017 оны мөн үеэс 23.2 хувь буюу 10.5 тэрбум ₮-өөр буурлаа.

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь ашигт малтмал олборлолт, өмнөх оноос 22.1 хувь буюу 8.4 тэрбум ₮-өөр буурсан нь нөлөөлөв.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Зуунмод, Баянцогт, Баянчандмань сумд 66.2-0.9 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 96.7) хувийг эзлэв.

Оны эхний 7 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 7.2, боловсруулах үйлдвэрлэл 8.5, ашигт малтмал олборлолт 84.3 хувийг тус тус эзлэв.




Энэ сард аж үйлдвэрийн гол нэр төрлийн 27 бүтээгдэхүүнээс 5 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдлээ. Нэр төрлөөр нь үзвэл: хөвөнтэй бээлий, плать, алт, зүсмэл материал зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, дулаан, сувагжуулалт, түгээсэн цэвэр ус, төмрийн хүдэр, талх, савхин гутал, ажлын хувцас, ундаа рашаан, арвайн гурил, төмөр эдлэл, шингэн сүү, нарийн боов, куртка, өмд, цамц желет, хэрчсэн гурил шохойн чулуу, монгол дээл, эсгий гутал, монгол гутал, бланк, хүснэгт маягт, спорт хослол, угаасан ноос, эмэгтэй хослол гэрийн модон эдлэл, жонш, ногооны консерв, бланк, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурав.


Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2018 оны эхний 7 сард оны үнээр 61.7 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн борлуулсан нь 2017 оны мөн үеийнхээс 20.1 хувь буюу буюу 15.5 тэрбум ₮-аар бүүрлаа.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Зуунмод, Баянцогт, Баянчандмань сумд 66.2-0.9 (эдгээр сумдын борлуулалт 96.7) хувийг эзлэв.

Оны эхний 7 сарын борлуулалтанд дулааны эрчим хүч 5.3, боловсруулах үйлдвэрлэл 5.6, ашигт малтмал олборлолт 89.1 хувийг түс түс эзлэв.



Аж үйлдвэрийн салбарт оны эхний 7 сард нийт 1523 хүн ажиллаж бүтээмж 23.0 сая ₮ байгаа нь 2017 оны мөн үеэс 22 хувиар буурч, 2016 оны мөн үеэс 1.1 дахин нэмэгдлээ.



Ахуй үйлчилгээний байгууллагууд оны эхний 7 сард 856 цэгт 914 хүн ажиллаж 1.5 тэрбум ₮-ийн орлого үйлчилгээний ажил хийж 599.5 сая ₮-ийн зардал гаргаж 110787 хүнд үйлчилжээ. Нийт орлогын 21.4 хувь нь оёдол, 12.9 хувь нь гутал, 4.9 хувь нь модон эдлэл, 28.4 хувь нь тээврийн хэрэгслийн болон ахуйн техникийн засвар, 20.0 хувь нь үсчин гоо засал, гэрэл зураг, 7.5 хувь нь халуун усны, 4.9 хувь нь бусад үйлчилгээний орлого эзлэв.



БАРИЛГА

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэд 2018 оны эхний 7 сард 5.6 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 50.6 хувь буюу 1.9 тэрбум ₮-өөр өсөв.

Барилга угсралт, их засварын ажлын 27.7 хувь нь орон сууцны барилгад; 36.1 хувь нь инженерийн барилга байгууламжид; 36.2 хувь нь орон сууцны бус барилгад ногдлоо. Үүнийг өмнөх онтой харьцуулахад орон сууцны барилгын ажил 16.5 пунктээр, орон сууцны

бус барилгын ажил 1.7 пунктээр тус тус өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 18.3 пунктээр буурав.




Дээрхи ажлуудаас гадна орон нутгийн болон улсын төсвийн санхүүжилт, ТББ, иргэдийн санхүүжилтаар манай аймгийн нутаг дэвсгэрт бусад аймаг, хотын харьяат гүйцэтгэгчид 2018 оны эхний 7 сард 5.2 тэрбум ₮-ийн дараах ажлуудыг гүйцэтгэжээ.



Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 7 сард 146.6 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 45.2 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.7 хувь буюу 59.1 сая ₮-өөр буурлаа.



Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 56.6 сая ₮ болсон ба нийт орлогын 73.9 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 26.7 хувийг албан бичгийн 3.6 хувийг зорчигчдын, 69.7 хувийг бусад орлого бүрдүүлжээ.



ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

Худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын үйл ажиллагааны мэдээг ҮСХ-ноос өгсөн түүврийн дагуу цуглуулдаг.

2018 оны 2-р улирлын мэдээгээр Төв аймагт худалдааны чиглэлээр 202 аж ахуй нэгж, зочид буудал зоогийн газрын чиглэлээр нийт 36 ААНБ үйл ажиллагаа явуулж байна.

2018 оны худалдааны мэдээний түүвэрт 45 ААНБ сонгогдсон ба 35 нь үйл ажиллагаа явуулсан. Эдгээр газрууд 2 дугаар улирлын мэдээгээр 8.0 тэрбум төгрөгийн орлого олжээ. Борлуулсан барааны өртөг нь нийт орлогын 97.5 хувийг эзэлж байна. Эдгээр 35 аж ахуй нэгжид нийт 88 ажилчин ажиллаж байгаагийн 45 нь эмэгтэй ажилчид ажиллаа.

Зоогийн газрын үйлчилгээ эрхэлдэг 11 аж ахуйн нэгж 2018 оны улирлын мэдээний түүвэрт сонгогдсон ба нийт орлого дүнгээр 235.6 сая төгрөг боллоо. Нийт орлогын 74.6 хувь нь хоолны орлогоос бүрджээ. Нийт зардал 238.4 сая төгрөг байгаагийн 67.1 хувийг ажилчдын цалин, НДШ-д зарцуулжээ.

Зочид буудлын үйлчилгээ эрхэлдэг 9 аж ахуйн нэгж 2018 оны улирлын мэдээний хүрээнд сонгогдон үйл ажиллагаа явуулсан. Эдгээр газруудын нийт орлого 1.1 тэрбум төгрөг, нийт зардал 1.5 тэрбум төгрөгт хүрэв. Орлого өнгөрсөн оны мөн үеэс 22.3 хувиар өслөө. Салбарт ажиллагчдын тоо 96, эмэгтэй 54 хүн байна.

2018 оны эхний 6 сард барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг хүрээнд сонгогдсон 4 аж ахуй нэгж байгууллагын орлого 56.3 сая ₮, зардал 50.9 сая ₮ болж 184.3 сая ₮-ийн зээл олгожээ.

Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ

2018 оны эхний 6 сард хүрээнд сонгогдсон нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгж байгууллагын орлого 18.7 сая ₮, зардал 25.2 сая ₮ зарцуулжээ.

Төрийн бус байгууллага

2018 оны эхний 2-р улиралд орлого 142.7 сая ₮, зарлага 151.3 сая ₮ байгаа нь 2017 оны мөн үеэс орлого 45.9 хувь буюу 121.2 сая ₮-өөр, зарлага 49.4 хувь буюу 147.9 сая ₮-өөр тус бүр буурлаа. Хүрээнд сонгогдсон төрийн бус байгууллагын ажилчдын тоо 60 байгаагийн 39 буюу 65.0 хувь нь Зуунмод суманд байна. Хүрээнд сонгогдсон нийт 33 төрийн бус байгууллага байгаагийн 54.5 хувь буюу 18 нь үйл ажиллагаа явууллаа.

Аялал жуулчлал

2018 оны эхний 6 сарын байдлаар аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг 12 аж ахуй нэгж байгууллага түүвэрт хамрагдаж, 3 аж ахуй нэгж үйл ажиллагаа эхлээгүй 9 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж нийт орлого 287.3 сая ₮, нийт зарлага 249.3 сая ₮ боллоо. 2018 оны эхний 6 сард гадаадаас хүлээн авсан жуулчид 53 болсны Япон 14, ХБНГУ 11, БНСУ 9, АНУ 9, БНХАУ 4 бусад улсаас 6 иргэнд үйлчилгээ үзүүлжээ.

Мал эмнэлэг

2018 оны 2 улиралын байдлаар мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг 68 аж ахуй түүвэрт сонгогдсоноос 58 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж орлого 181.6 сая ₮,

зардал 188.5 ₮ болж, нийт 1127294 мал үйлчилгээнд хамрагдлаа.

Мэргэжлийн түр сургалт

2018 оны эхний 2-р улиралд түүврээр сонгогдсон мэргэжлийн түр сургалт явуулдаг аж ахуй нэгж байгууллагын орлого 20.2 сая ₮ байгаа нь өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар буурч, 19.3 сая ₮ зарцуулж сургалтанд 80 иргэн хамрагджээ.

Статистикийн хэлтэс